



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН 2018



ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтыг биелүүлэхүйц, Монгол хүний эрхийг хангасан баталгаатай, тэгш, хүртээмжтэй усны үйлчилгээг үр өгөөжтэй, тогтвортой, байгаль орчинд ээлтэй хөгжүүлэх оновчтой зохицуулалтыг хийхэд оршино.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО №1	Усны үйлчилгээг хэрэглэгчид шударгаар, тэгш хүртэх боломжийг хангах;
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО №2	Усны үйлчилгээний давамгайл байдалд үр дүнг чухалчилсан зохицуулалт хийх;
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО №3	Хангагч байгууллагын хариуцлагыг дээшлүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх;
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО №4	Тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх;
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО №5	Мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн манлайлагч байгууллага болох

ОРШИЛ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт зааснаар Зохицуулах Зөвлөл нь тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй бөгөөд хуулийн 10 дугаар зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Зохицуулах Зөвлөл Монгол Улсад ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг үр ашигтай явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэн, дэлхийн жишигт нийцсэн чанар стандарт бүхий найдвартай, тэгш, хүртээмжтэй үйлчилгээг хот, суурины хэрэглэгчдэд хүргэх, баталгаажуулах оновчтой зохицуулалтыг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.

НЭГ. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ



ҮНЭ, ТАРИФЫН ЧИГЛЭЛЭЭР

1.1 Хуулийн 10.1.1 дэх заалт буюу цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр тогтоох аргачлал, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчилгээний тарифыг хянаж батлах, нийтлэх ажлын хүрээнд:

Тарифын санал ирүүлсэн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хэрэглэгчийн тарифт зохицуулалт хийж, холбогдох материалыг бүрдүүлэн Захиргааны ерөнхий хуулийн 64.1-д заасны дагуу нөлөөллийн шинжилгээг хийн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Тус зохицуулалтад нийт 30 орчим аймаг, сумын төв болон төмөр замын дагуух суурин газрууд хамрагдлаа.




Улаанбаатар хотын цэвэр, бохир усны тарифыг 2018 оны 32 дугаар тогтоолоор шинэчлэн тогтоосонтой холбогдуулан тусгай зөвшөөрөл эзэмшигч 85 аж ахуйн нэгж, байгууллагын зардалд хяналт хийж бөөний тариф тогтоосон бөгөөд 32 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ирүүлсэн материалыг хянаж борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ, УСУГ зэрэг хангагч байгууллагатай тооцоо хийх цэвэр, бохир

усны бөөний тарифыг шинэчлэн мөрдүүлсэн. Түүнчлэн 12 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ОСНАУГ-тай тооцоо хийх дамжин тарифыг хянаж батлуулав.

График 1. Тарифын зохицуулалт



График 2. УХАТ-ын үзүүлэлт, 2018 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл



Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаанаасаа 2018 онд 152.0 тэрбум төгрөгийн орлоготой ажиллахаар төлөвлөсөн боловч хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 160.0 гаруй тэрбум төгрөгийн орлоготой ажиллаж төлөвлөгөө 106%-иар биелэх төлөвтэй байна. Мөн онд ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаанд 175.0 тэрбум төгрөгийн зардалтай ажиллахаар төлөвлөж байсан бол хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 171.0 тэрбум төгрөг болж зардлын төлөвлөгөө 97.7% хувийн гүйцэтгэлтэй буюу 4.0 орчим тэрбум төгрөгийн зардал төлөвлөснөөсөө хэмнэж ажиллах боломжтой байна.





2018 онд тарифын зохицуулалтаар салбарын орлого 8 тэрбум орчим төгрөгөөр нэмэгдэх бөгөөд Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зардалд хяналт хийн, төлөвлөсөн зардлыг 3 тэрбум төгрөгөөр хэмнэх боломжтой гэж үзэж, үүрэг, даалгавар өгч ажиллаа.



Зөвлөлийн ажлын албанаас “Цэвэр усны шугам хоолойд угаалга хийх үйлчилгээний төлбөр тооцох аргачлал” боловсруулан Зохицуулах зөвлөлийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор батлуулсан нь хэрэглэгчдээс ирүүлж буй үйлчилгээний төлбөр өндөр байгаа тухай гомдол барагдуулахад чухал алхам болсон. Ус дамжуулах хоолойн угаалга хийх үйлчилгээний төлбөрийг тухайн орон нутагт мөрдөгдөж байгаа аж ахуйн нэгжийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифаар тооцож нэхэмжлэх аргачлалыг боловсруулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн билээ.


Цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, төлбөр тооцох аргачлалыг шинэчлэн батлуулсантай холбогдуулан тариф тооцох загвар боловсруулж, зүгшрүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд аргачлалыг мөрдөх заавар боловсруулав. Түүнчлэн энэ ажлын хүрээнд Зохицуулах зөвлөлийн дотоод үйл ажиллагаанд мөрдөх “Цэвэр, бохир усны үйлчилгээний тариф хянан шалгах дотоод журам”-ыг шинэчлэн Зохицуулах зөвлөлийн 2018.12.21-ний өдрийн 107 дугаар тогтоолоор батлуулаа.

1.2 Хуулийн 10.1.2 дахь заалт буюу үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийн хэмжээг тогтоох ажлын хүрээнд:

Ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын элэгдлийн хэмжээг тогтоох төслийг батлуулан нөлөөллийн шинжилгээ хийж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу файлын сан үүсгэн Хууль зүйн яаманд хүргүүлж, бүртгүүлсэн.

Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийн хэмжээ тогтоох журам гарсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагаас авах үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын тайлан, тарифт тусгасан хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг авах маягт боловсруулсан болно.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЧИГЛЭЛЭЭР



1.3 Хуулийн 10.1.3 дахь заалт буюу Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох ажлын хүрээнд:

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох нийт 81 материалыг тухай бүр хүлээн авч хянан, үүнээс тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага хангасан 67 аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах, цуцлах болон нэр солих асуудлыг Зохицуулах зөвлөлийн хуралдаанд оруулан хэлэлцүүлж, шийдвэрлэв.

Тайлант хугацаанд 13 аж ахуйн нэгж байгууллагад ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгож, 52 аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгаж, 2 аж ахуйн нэгж байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцалж, 1 аж ахуйн нэгж байгууллагын нэр солих зэрэг асуудлыг шийдвэрлэн, Тусгай зөвшөөрлийн гүйцэтгэлийн гэрээг шинэчлэн байгуулсан байна.


Шинээр олгосон тусгай зөвшөөрөл

Хүснэгт 1

№	Тусгай зөвшөөрлийн нэр, төрөл	Олгосон тоо
1.	Орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам, сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр	2
2.	Аймаг, орон нутгийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр	2
3.	Бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээний чиглэлээр	8
4.	УХАТ-ын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ	1
Нийт		13

График 3. Тусгай зөвшөөрөл олгосон байдал


Тусгай зөвшөөрөл шинээр олгосон төрлийн эзлэх хувь



- Орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам, сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр
- Аймаг, орон нутгийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр
- Бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээний чиглэлээр
- УХАТ-ын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ

Түүнчлэн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тусгай зөвшөөрлийг орон сууцны ашиглалт, үйлчилгээ эрхлэх чиглэлээр 25 аж ахуйн нэгж, байгууллага, орон нутгийн нийтийн аж ахуйн 18 байгууллага, ус хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмжид туршилт тохируулга хийдэг 1, бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ эрхэлдэг 8 нийт 52 аж ахуйн нэгж, байгууллага сунгуулсан байна.

График 4. Тусгай зөвшөөрлийн шийдвэрлэлтийн байдал




2018 оны байдлаар улсын хэмжээнд ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг харуулбал:

Хүснэгт 2

№	ТЗЭ-ийн төрөл	Тоо
1.	Орон нутгийн НАА-н байгууллагууд	48
2.	Улаанбаатар хотын ОНӨААТҮГ-ууд	6
3.	Улаанбаатар хотын хувийн хэвшлийн-ТЗЭ	83
4.	УХАТ-ын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ	2
5.	Цэвэр ус цэвэршүүлэн савлах үйлдвэр-ТЗЭ	2
6.	Бохир усыг тусгай зориулалтын машинаар соруулах үйлчилгээтэй ТЗЭ	46
Нийт		187

График 5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төрөл.





Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан болон шинээр авсан Тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 65 аж ахуйн нэгж, байгууллагатай Тусгай зөвшөөрлийн гүйцэтгэлийн гэрээг шинэчлэн байгуулав.

1.4 Хуулийн 10.1.4 заалт буюу Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах:



Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах хүсэлт гаргасан 62 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай газар дээр нь очиж шалган, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын дагуу дүгнэлт гарган ажиллав. Тухайлбал, Улаанбаатар хот, Сэлэнгэ аймаг зэрэг орон нутгийн нийт 14 байгууллагын үндсэн үйл ажиллагаатай танилцан, тухайн нутаг дэвсгэрт ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний хүртээмж, чанарт дүн шинжилгээ хийж, цаашид анхаарч ажиллах шаардлагатай зүйлсийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажиллав.

Зохицуулах зөвлөлөөс 2018 оны хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөг боловсруулж, баталсаны үндсэн дээр хяналт, шалгалтын ажлыг графикийн дагуу хийж гүйцэтгэлээ. Үүнд:

2018 онд Нийслэлийн нутаг дэвсгэрт ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар үйлчилгээ эрхэлж буй тусгай зөвшөөрөл бүхий давхардсан тоогоор хувийн хэвшлийн 38 аж ахуйн нэгж, байгууллагуудад хэрэглэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа.



Дээрх хяналт шалгалтанд хамрагдсан байгууллагуудын үйл ажиллагаа нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай зэрэг хууль, холбогдох норм, дүрэм,

стандартын хэрэгжилт, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж буй эсэхэд дүгнэлт гаргах зорилгоор Зохицуулах зөвлөлийн даргын баталсан хяналт шалгалтын хуудсаар тухайн байгууллагад үнэлэлт өгөх, ажил үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах үйлчилгээг газар дээр нь өгч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч ажиллаа.



Хяналт шалгалтаар аж ахуйн нэгж байгууллагуудад илэрсэн нийтлэг зөрчил дутагдлаас дурдвал:

- Орон нутгийн байгууллагуудад мэргэжлийн инженер техникийн ажилчид дутмаг;
- Тоног төхөөрөмжийн хаягжилт, ашиглалтын журнал, аюулгүй ажиллагааны дэвтэр тогтмол хөтөлдөггүй;
- Диспетчерийн ажлын байрны нөхцөл Орон сууцны барилгын үйлчилгээ MNS5681:2006 стандартын шаардлагыг хангаагүй;
- Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого чиглэл тодорхойгүй, санхүүгийн бүртгэлийг зохих шаардлагын дагуу хөтөлдөггүй зэрэг болно.

Цаашид Зохицуулах зөвлөлөөс тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын хүрээнд салбарт мөрдөгдөж буй хууль, тогтоомж, норм дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах, цэвэр, бохир усны үйлчилгээний чанарыг сайжруулах үүднээс хяналт шалгалтын давтамжийг ойртуулах, тодорхой үр дүнд хүрэх нь чухал байна.

1.5 Хуулийн 10.1.5 заалт буюу Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх ажлын хүрээнд:



2018 онд иргэн, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн өргөдөл, гомдолыг 100 хувь шийдвэрлэсэн бөгөөд ирүүлсэн өргөдөл, гомдлыг ангилан авч үзвэл:

31 хувь нь өр, төлбөртэй холбоотой, 17 хувь нь үйлчилгээний чанарын талаар, 23 хувь нь ус тасалдах болон ус хангамжийг хязгаарладаг тухай, үлдэх 19 хувь нь хэмжих хэрэгслийн талаар болон өмчлөл, СӨХ-ны үйл ажиллагаатай холбоотой байв.

Хангагч, хэрэглэгчийн хооронд үүссэн төлбөрийн 21, тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд үүссэн төлбөр тооцоотой холбоотой 9 маргаантай асуудлыг шийдвэрлэж, холбогдох арга хэмжээ авлаа.

1.6 Тусгай зөвшөөрлийн журам, аргачлал, зааврыг боловсронгуй болгох, хууль, дүрэмд санал өгөх чиглэлээр:



- Цэвэрлэх байгууламжийн төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан Баян-Өлгий, Завхан, Говьсүмбэр, Увс, Дорнод аймгуудын НААҮ-ний байгууллагуудын ариутгах татуургын системийн техник технологийн байдлын талаар материал бэлтгэн БХБЯ-д хүргүүлэв.
- Үндэсний статистикийн хорооноос 2020 онд явуулах хүн ам, орон сууцны тооллоготой холбогдуулан зохион байгуулах хэлэлцүүлэгт шаардлагатай мэдээллийг бэлтгэн БХБЯ-д хүргүүлэв.
- Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад нэмэлт, өөрчлөлт оруулахаар Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулж, Зохицуулах зөвлөлийн 2018.01.19-ны өдрийн хуралдааны 12 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018.01.30-нд бүртгүүлэв.
- Ус дамжуулах шугам хоолойн угаалга хийх үйлчилгээний төлбөр тооцох журмын төслийг боловсруулж мэргэжлийн 7 байгууллагаас санал авч, Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Барилга, хот байгуулалтын сайдын

2018.11.23-ны 195 тоот тушаалаар батлуулав.

- 2020 онд Хүн ам, орон сууцны тооллого явуулахтай холбогдуулан салбарын статистик мэдээллийн одоогийн байдал, хэрэгцээ шаардлага сэдвээр илтгэл бэлтгэж БХБЯ-д хүргүүлэв.
- Завхан аймгийн "Амь Ус трейд" ОНӨААТҮГ, Сэлэнгэ аймгийн "Урсгал ус" ХХК, Баян-Өлгийн аймгийн "Суат" ХХК, Улаанбаатар хотын "Голд Компас" ХХК, "Комфорт монгол нэтворк" ХХК, "Хилийн цэргийн 0288 анги" ТӨААТҮГ, "Эгц шугам" ХХК, зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын инженер техникийн ажилтнуудад тайлан мэдээ гаргах, тусгай зөвшөөрлийн материал бэлдэх заавар зөвлөлгөө өгч ажиллав.
- МСК-аас хэрэгжүүлж буй дахин цэвэршүүлэх байгууламжийн төслийн хэлэлцүүлэг, мөн БХБЯ-аас зохион байгуулагдсан "Ногоон барилга" сургалт, БОНХЯ-ны "Хот суурин газрын ус намгархаг газар", "Үйлдвэрлэлийн технологийн усыг дахин ашиглах техникийн шаардлага стандарт" төсөл, Туул голын сав газрын захиргааны "Байгальд ээлтэй усны шийдэл" уриатай хэлэлцүүлгүүдэд тус тус оролцож, холбогдох саналаа өгөв.



- Аж ахуйн харилцааны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хэлэлцүүлэг хийж, тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас санал авч ажилласны үр дүнд 20 гаруй байгууллагын санал, зөвлөмжийг тусгав.
- "Туул голын сав газрын захиргаа"-наас ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын судалгааг авах хүсэлт ирүүлсний дагуу холбогдох судалгаа, мэдээллийг хүргүүлэв.
- БХБЯ-ны хамран ажиллах тухай албан бичгийн хүрээнд Засгийн газрын 121 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний дагуу "Орон сууц" үндэсний хөтөлбөрт 2018 оны 01/208 тоотой санал өгч, хүргүүлсэн.
- Монгол Улсын Засгийн газрын 73 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн лагийн үнэрийг арилгах ажлын хэсэгт орж ажиллан, тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас ус бохирдуулагч ААНБ-уудын судалгааг авч нэгтгэн дүгнэлт гарган, танилцуулгыг бэлтгэн БХБЯ-д хүргүүлэв.

- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар холбогдох судалгааг гаргуулахаар БОАЖЯ-аас 2018.05.14-ний өдөр БХБЯ-д албан бичиг хүргүүлсний дагуу тус Зохицуулах зөвлөлөөс тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын цэвэрлэх байгууламжуудын мэдээ, судалгааг гаргаж, хүргүүлэв.

- Үндэсний хөгжлийн газраас зохион байгуулж буй “Байгаль орчны салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох” хэлэлцүүлгийн “Усны нөөцийн менежмент” багт орж ажиллан, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ийг хэрэгжүүлэх дунд хугацааны нэгдсэн төлөвлөгөөнд санал өгч, хамтран ажиллав.



- Цэвэрлэх байгууламжийн төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан Баян-Өлгий, Завхан, Говьсүмбэр, Увс, Дорнод, Дорноговь, Өмнөговь аймгуудын НАА-н байгууллагууд, Дархан ус суваг ХК, Эрдэнэт үйлдвэр зэрэг нийт 9 байгууллагын цэвэрлэх байгууламжид хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн талаар мэдээ, судалгааг дээрх байгууллагуудаас авч нэгтгэв.
- БХБЯ-д ахуйн болон үйлдвэрээс гарсан нийт бохир усны хэмжээ 2014, 2015, 2016 оны, цэвэрлэх байгууламжуудад цэвэрлэсэн усны хэмжээ 2014, 2015, 2016 оны судалгааг хүргүүлэв.
- Монгол Улсын Засгийн газрын 2018.03.14-ний 73 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Барилга, хот байгуулалтын Сайдын 111-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллан, УБ хотын төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэх бохир усны стандартын шаардлагыг хангуулах ажлыг зохион байгуулахад оролцон, ус бохирдуулагч үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагуудын мэдээллийг авч, 7 төрлөөр ангилан, холбогдох судалгааг

хийж, танилцуулга бэлтгэв.

- БХБЯ-ны цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлын сонгон шалгаруулах журамд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан төрлүүдээс оруулахаар санал хүргүүлэв.
- Ус хангамж, ариутгах татуургын техник ашиглалтын дүрмийг боловсруулж, Барилга, хот байгуулалтын Сайдаар батлууллаа.
- Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын бүтэц, орон тооны жишиг загварыг боловсруулж БХБЯ-нд хүргүүлэв.
- Ундны усны аюулгүй байдлын хэрэгжилтийг хангуулах багц дүрэм, журам, зааврыг Зохицуулах зөвлөлийн 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, Барилга хот байгуулалтын сайдад хүргүүлэв.
- Цэвэрлэх байгууламжийн угсралтын ажилд тусгай зөвшөөрөл олгож, хяналт тавих зорилгоор Зохицуулах зөвлөлийн 2018.11.30-ны 95 тоот тогтоолоор тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад нэмэлт оруулан Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэв.





ХОЁР. ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХЭД ХАМААРАХ АСУУДЛААР ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРАМ, ЗААВРЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ



- 2.1 Зохицуулах зөвлөлийн 2019-2022 оны Стратегийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлав.
- 2.2 Барилга, хот байгуулалтын яамнаас Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах суурь судалгааны зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтаар шалгарсан “Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэн” ТББ-тай хамтран ажиллаж байна.
- 2.3 Цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, төлбөр тооцох аргачлалыг Зохицуулах зөвлөлийн 2018 оны 11 дүгээр тогтоолоор баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэв.
- 2.4 Цэвэр усны шугам хоолойд угаалга хийх, үйлчилгээний төлбөр тооцох аргачлалыг Зохицуулах зөвлөлийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор батлав.
- 2.5 Тус Зохицуулах зөвлөлийн ажлын албаны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах асуудлыг судлан үзэж, Зөвлөлийн 2018.05.28-ны өдрийн 48 тоот тогтоолоор батлав.
- 2.6 Зохицуулах зөвлөлийн ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, даргын 2018.05.31-ний А/20 тоот тушаалаар батлав.



- 2.7 Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 107, 208 дугаар тогтоолоор тус Зохицуулах зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төсөв батлагдсантай холбогдуулан байгууллагын ажилтан, албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээнд өөрчлөлт оруулан Зохицуулах зөвлөлийн даргын 2018.05.31-ний А/21, 2018.10.04-ний А/45 тоот тушаалаар тус тус батлуулав.
- 2.8 Зохицуулах зөвлөлийн 1-12 дугаар сард ээлжит болон ээлжит бус хуралдааны бэлтгэл ажлыг зохион байгуулж, нийт 108 тогтоолын төслийг хянаж, батлагдсаны дараа холбогдох албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагад хувийг хүргүүлэн ажиллав.
- 2.9 Тус Зохицуулах зөвлөлийн даргын нийт 104 тушаал /үйл ажиллагаатай холбоотой 64, боловсон хүчний 40/-ын төслийг боловсруулах, хууль зүйн үндэслэл, зохицуулалтыг хянах, батлагдсаны дараа холбогдох албан тушаалтанд танилцуулах ажлыг зохион байгуулав.
- 2.10 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан нийт 32 гэрээний төслийг боловсруулах, хянах, бүртгэх ажлыг хийж, тэдгээртэй гэрээ байгуулан ажиллав.

ГУРАВ. ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

- 3.1 2018 оны жилийн эцсийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 795 албан бичиг хүлээн авч бүртгэл хөтөлсөн. Үүнээс хаагдсан 764, шийдвэрлэх шатандаа 31 /гүйцэтгэл 96.1%/ албан бичиг байна. Мөн нийтдээ 563 албан бичгийг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад явуулав.
- 3.2 2018 оны эцсийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийтдээ 87 өргөдөл, гомдол ирүүлсэнээс боловсон хүчинтэй холбоотой 43 хувь, иргэн, хуулийн этгээдийн гомдол 57 хувийг эзэлж байна. Тайлант онд ирүүлсэн өргөдөл гомдлын 92 хувийг шийдвэрлэсэн бөгөөд үлдэх хэсэг нь шийдвэрлэгдэх шатанд явж байна.
- 3.3 Ажлын албаны орон тооны ажилтан, албан хаагчдын 2018 оны I-IV улирлын ажлын гүйцэтгэлийн үнэлгээний нэгтгэлийг хийж, үйл ажиллагааны тайланг гаргав.



- 3.4** 2018 оны байдлаар гадаад улс руу 7, орон нутагт 9, хотод 16 удаа тус тус томилолтоор ажилласан бөгөөд ажлын үр дүн, зардлын тооцоог тайлагнав.
- 3.5** Зохицуулах зөвлөлийн даргын итгэмжлэлээр хууль, хяналтын байгууллагад Зохицуулах зөвлөлийг төлөөлөн дараах ажлуудыг хийв. Үүнд:
- Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байгаа иргэн Ч.Саранхүүгийн нэхэмжлэлтэй иргэний хэрэгт хариу тайлбар гаргах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардагдах нотлох баримтыг гаргах, анхан, давж заалдах, хяналтын шатны шүүх хуралдаанд тус тус оролцов. Хяналтын шатны шүүхээс Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж буюу уг хэргийг анхан шатны шүүхээр дахиж шийдвэрлүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд анхан шатны шүүхээс хэргийг буцаалгаж шийдвэрлэв.
 - Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байгаа “Харуул-Алтай” СӨХ болон иргэн М.Баярсайхан нарын нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт хариу тайлбар болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардагдах нотлох баримтыг гаргах, анхан болон давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцов. Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх буюу нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.



- Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байгаа “Баатар дулаан хан” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт хариу тайлбар, хүсэлт гаргах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардагдах нотлох баримтыг гаргах, анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд оролцов. Захиргааны хэргийн Хяналтын шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.
- Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байгаа иргэн Б.Нандин-Эрдэнийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт хариу тайлбар болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардагдах нотлох баримтыг гаргах, анхан

шатны шүүх хуралдаанд оролцов. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.

- Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд шүүх болон Давж заалдах шатны шүүхэд хянагдаж байгаа “Тулга констракшн” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны 2 хэрэгт хариу тайлбар, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардагдах нотлох баримтыг гаргах, холбогдох хүсэлтийг гаргаж анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд оролцов. Давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.
 - Зохицуулах зөвлөлийн нэхэмжлэлтэй Дундговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч С.Сүхбаатарт холбогдох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч тал нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж маргаан бүхий усны үнэ тариф тогтоосон тогтоолыг хүчингүй болгов.
 - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байгаа “Зүмбэр орд өргөө” ХХК-ийн нэхэмжлэлтэй иргэний хэрэгт хариу тайлбар болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардагдах нотлох баримтыг гаргах, холбогдох хүсэлт гаргах, анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд оролцов. Шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангахгүй орхиж шийдвэрлэв.
 - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017.12.28-ны 98 тоот, 2018.01.24-ний 365 тоот, 2018.11.29-ний 3769 тоотын дагуу холбогдох нотлох баримтыг бэлтгэж, Зохицуулах зөвлөлийн 2017.01.04-ний 01/06, 2018.01.25-ны 01/42, 01/534 тоотоор тус тус хариу хүргүүлэв.
 - Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018.12.03-ны 1/8860 тоотын дагуу “Конфорт таун инвест” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн материал, холбогдох нотлох баримтыг бүрдүүлэн Зохицуулах зөвлөлийн 2018.12.03-ны 01/538 тоотоор хариу хүргүүлэв.
 - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018.12.17-ны 1/3423 тоотын дагуу холбогдох нотлох баримтыг бэлтгэж, Зохицуулах зөвлөлийн 2018.12.18-ны 01/560 тоотоор хариу хүргүүлэв.
- 3.6** Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад тэмдэглэл үйлдэх ажлын хүрээнд давхардсан тоогоор нийт 85 аж ахуйн нэгж, байгууллагын орон сууцны бүртгэлийг Зохицуулах зөвлөлийн мэдээллийн санд бүртгэв.





- 3.7 Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд 2018 онд шинэчлэн батлагдсан Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөв. Мөн Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн бүрдүүлэх маягтыг шинэчлэн батлуулж, Зөвлөлийн цахим хуудаст байршуулав.
- 3.8 Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын усны алдагдлыг бууруулах, түүнд мониторинг хийх, усны балансыг зөв тооцох ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн "Урсгал ус" ХХК, Дархан-Уул аймгийн "Дулаан шарын гол" ОНӨААТҮГ, Булган аймгийн "Булган мээж" ХХК-иудын инженер, техникийн ажилтануудтай уулзаж, тухайн байгууллагуудын усны алдагдлыг судалж, горим тохируулга хийх аргачлал, усны балансыг хэрхэн зөв тооцох, шугам сүлжээнд суурилуулах тоолуурын талаар зөвлөмж хүргүүлсэн.
- 3.9 Гэрээ болон удирдах ажилтны анкетын бүрдэлт дутуу орон нутгийн 37 аж ахуйн нэгж, байгууллага, орон сууцны 30 байгууллагатай холбогдсоны дүнд иж бүрдлийг гүйцээж, нийт орон нутгийн 51, орон сууцны цэвэр, бохир усны ашиглалт, үйлчилгээний 86, бохир ус тусгай зориулалтын машинаар соруулах үйлчилгээний 55 байгууллагын гэрээ, удирдах ажилтны анкетын бүрдлийг бий болгов.
- 3.10 "Дэлхийн 00-н өдөр"-т зориулж нүхэн жорлонг шинэчлэн хөрсөнд бохир шингэдэггүй байхаар сайжруулах ажлыг тухайн орон нутагтаа зохион байгуулах үүрэг даалгаврыг нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд өгч ажиллав.
- 3.11 Зохицуулах зөвлөлийн ажилтан, албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Сүхбаатар дүүргийн 8-р хорооны нутаг дэвсгэрт байрлах N tower байрны 6 дугаар давхрыг байгууллагын бүтэц, зохион байгуулалттай уялдуулан засвар хийлгүүлэн орж, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэв.
- 3.12 Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай заавар, аргачлалыг шинэчлэн баталж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хүргүүлэв.




ДӨРӨВ. ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭР, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

- 4.1 Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны талаар өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүр олон нийтэд мэдээлэх ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнд:
- Дэлхийн усны өдрөөр зохион байгуулсан сургалтын мэдээллийг 2018.03.22-ны өдрийн "Өнөөдөр сонин"-ы №053/6346/р, "Өдрийн сонин"-ны №061/5904/ дугаарын 15-р нүүрт тус тус байршуулсан.
 - 2018.03.24-ний өдрийн ТМ телевизийн "Өдрөг өглөө" нэвтрүүлэгт Зохицуулах зөвлөлийн төлөөлөгч оролцов.
 - Улаанбаатар хотын усны үйлчилгээний тарифт зохицуулалт хийсэн мэдээллийг Өнөөдөр сонины 2018.04.04-ний өдрийн №065(6358) дугаарын С2 нүүрт хэвлүүлсэн.
 - УХАТ-2018 сургалтын мэдээллийг Өдрийн сонины 2018.04.27-ны өдрийн №088(5931) дугаарын 2-р нүүрт хэвлүүлсэн.
 - "Хэрэглэгчээ сонсьё" нээлттэй хаалганы өдөрлөгийн хүрээнд 2018.10.12-ны өдөр Монгол Ньюсын мэдээллийн төвд хэвлэлийн бага хурал зохион байгуулсан. Мөн тус өдөрлөгийн талаарх мэдээллийг 2018.10.29-ний өдрийн "Өнөөдөр сонин" №208(6501) дугаарын А11 нүүрт, 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн "Өдрийн сонин" №214,2015 (6057,6058) дугаарын 14-р нүүрт тус тус хэвлүүлсэн.





- Ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрлийн материал бэлдэх болон түүнтэй холбоотой бусад дүрэм, журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан байгууллагын сайтад холбогдох мэдээллийг шинэчлэв.



- 4.2** Зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь нь дараах олон нийтийн телевизүүдэд мэдээ, ярилцлага өгсөн. Үүнд:
- 2018 оны 11-р сарын 12-ны өдөр Монголын Үндэсний телевизийн ярилцлаганд ус хангамж, ариутгах татуургын өнөөгийн байдал, цэвэрлэх байгууламжийн талаар;
 - 2018 оны 11-р сарын 13-ны өдөр Star TV-ийн мэдээний ярилцлаганд Дэлхийн 00 өдрийн талаар болон цэвэрлэх байгууламжуудад хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн талаар;
 - 2018 оны 11-р сарын 14-ний өдөр TV8-ийн “Үнэнийг өөрөөсөө” нэвтрүүлэгт Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийн хүртээмжийн талаар;
 - 2018 оны 11-р сарын 14-ний өдөр Bloomberg TV Mongolia-гийн Зочны нэвтрүүлэгт салбарын санхүү эдийн засгийн байдал, хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, усны алдагдал, усны чанар, усны үйлчилгээний үнэ тарифын талаар тус тус олон нийтэд мэдээлэл хүргэсэн.



- 4.3** Цахим хуудсанд мэдээлэл тавих, хэрэглэгчдийн санал хүсэлтийг тусган, байнгын, эрчимтэй явцыг ханган ажиллах ажлын хүрээнд байгууллагын вэб сайтад дараах мэдээллийг байршуулав. Үүнд:
- Зохицуулах зөвлөлийн 2018 оны 1-12 дугаар сард зохион байгуулагдсан хуралдааны төлөвлөгөө, зар болон шийдвэрийг тус тус олон нийтэд мэдээлэв;
 - Веб сайтад 2018 оны байдлаар нийтдээ 92 удаа мэдээлэл шинэчлэн байршуулсан.
 - Байгууллагын вебсайтыг англи хэл дээр хөрвүүлэх ажлыг зохион байгуулав.
 - Байгууллагын фейсбүүк хуудсанд Зохицуулах зөвлөлөөс зохион байгуулсан үйл ажиллагаа, арга хэмжээний зурагт постеруудыг тогтмол бэлтгэж, байршуулах ажлыг гүйцэтгэж байна.
- 4.4** Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Зохицуулах зөвлөлөөс санаачлан “Ус ба байгаль” сэдвийн хүрээнд дараах ажиллуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:
- Хүүхэд багачуудыг усны зөв зохистой хэрэглээнд уриалах зорилгоор “Бомбоолой голоо аварсан нь” зурагт номын зургийг зурах болон хэвлэх санхүүгийн эх үүсвэрийг Зохицуулах зөвлөл болон НҮБ-ын ЮНЕСКО, “Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ, “Орон сууц нийтийн аж ахуйн мэргэжлийн холбоо” ТББ, “Хувийн орон сууц нийтийн аж ахуйн хөгжлийн төв” ТББ, “Дунд мандал” ХХК, “Лхатонот сервис” ХХК-иудтай хамтран 5000 ширхэг хэвлүүлж, хэрэглэгчдэд хүргүүлэв.
 - “Ус ба байгаль” сэдвээр 40 минутын хичээлийг 2018.03.21-ний өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 112 сургуулиудын бага, дунд, ахлан ангийн нийт 220,0 гаруй мянга сурагчдад мэргэжлийн инженер, техникийн нийт 130 гаруй мэргэжилтэн, ажилтнууд тухайн сургуулиудын багш нартай хамтран тус хичээлийг зохион байгуулсан.






- Тус өдрийн хичээлийн мэдээ, сургуулийн хуваарилалтыг веб сайтад байршуулж, холбогдох байгууллагуудад өгсөн бөгөөд зохион байгуулсан ажлын талаар Өдрийн сонин, Өнөөдөр сонинд нийтлүүлж, <http://news.gogo.mn/r/223327> сайтад байршуулсан.
- Туул голын сав газар, MCS-Coca cola компаниас 2018.03.16-ны өдөр хамтран зохион байгуулсан "Байгальд ээлтэй усны шийдэл" үзүүлэх сургалтад оролцож, MCS-Coca cola компаний үйл ажиллагаа болон тэдний шинээр ашиглалтад орсон цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай танилцав.
- 4.5 Усны салбарын 80 жилийн ойг зохион байгуулах ажлын хэсэгт оролцож, үзэсгэлэн, видео танилцуулга бэлтгэхэд хамтран ажилласан.
- 4.6 БОАЖЯ-аас 2018.09.27-ны өдөр Засгийн газрын ордонд зохион байгуулсан "Усны хөгжил дэвшил ба сайн засаглал" сэдэвт хэлэлцүүлэгт нэр бүхий 2 төлөөлөгчийг оролцуулав.
- 4.7 Зохицуулах зөвлөлийн даргын мэндчилгээ болон үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг 2018.06.27-ны өдөр "Монголын Нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо" ТББ-аас эрхлэн гаргадаг "Орчин 21" сэтгүүлд өгч нийтлүүлэв.
- 4.8 МХЕГ-аас орон сууцны барилга, байгууламжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын дунд "Зэвтэй ус, түүнийг арилгах арга зам" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулахад төлөөллөө оролцуулан, санал солилцов.

ТАВ. ГАДААД БОЛОН ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- 5.1 Тайландын Бангкок хотноо 2018.05.23-наас 27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Азийн Усны хорооны Удирдах зөвлөлийн 6-р хуралдаанд тус Зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь, Үнэ тарифын албаны дарга Ж. Гэрэлчулуун нар оролцов.



- 5.2 Монгол дахь НҮБ хүүхдийн сангийн суурийн төлөөлөгчийн газар хүсэлт хүргүүлсний дагуу 2018.06.18-22-ны өдрүүдэд Тайландын Бангкок хотноо зохион байгуулагдсан НҮБ-ийн Хүүхдийн сангийн "WASH Enabling Environment, and the Bottleneck Analysis Tool for UNICEF EAP Region" сургалтад Үнэ тарифын албаны дарга Ж.Гэрэлчулуун НҮБ-ийн Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр оролцов.
- 5.3 Зохицуулах зөвлөлийн ажлын алба Эрчим хүчний зохицуулах хороотой хамтарсан ажлын хэсэг байгуулав.



- 5.4 БНСУ-ын Дэжон хотноо 2018.09.10-11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Азийн усны хорооны удирдах зөвлөлийн 7-р хурал (BoC)-д Зохицуулах зөвлөлийн 2 төлөөлөгч оролцов.



5.5 Олон Улсын Усны холбооноос 2018 оны 09 дүгээр сарын 17-21-ний өдрүүдэд Япон улсын Токио хотод зохион байгуулагдсан “Усны үйлчилгээний зохицуулах байгууллагуудын нэгдсэн V чуулга уулзалт” болон “Дэлхийн усны чуулга уулзалт, үзэсгэлэн-2018”-д тусгай зөвшөөрөл эзэмшигч 5 аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, тус Зохицуулах зөвлөлөөс 3 албан хаагчид оролцов.



5.6 Бүгд Найрамдах Сингапур улсын Гадаад харилцааны яамнаас Сингапурын усны агентлаг болон НҮБ-ийн Хүүхдийн сантай хамтран 2018.10.08-12-ны өдрүүдэд Сингапур улсад зохион байгуулагдсан “Усны тогтвортой хөгжил ба тэгш байдлыг хангах нь” тэтгэлэгт сургалтад Эрх зүй, мэдээлэл, захиргааны албаны дарга Б.Доржбат оролцов.



5.7 Олон Улсын Усны холбооноос 2018.11.18-21-ний өдрүүдэд Австрали улсын Брисбан хотод зохион байгуулсан “Бохир усыг цэвэрлэх, дахин ашиглах технологийн бага хурал 2018”-д тус Зохицуулах зөвлөлийн төлөөлөгчид оролцов.



5.8 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын албан хаагчдыг чадваржуулах, мэргэжил арга зүйг сайжруулах асуудлаар гадаад, дотоодын сургалтыг зохион байгуулах, усны үнэ цэнэ, түүний зөв зохистой хэрэглээний талаар гарын авлага боловсруулах, олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор “Монголын Нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо” ТББ-тай хамтран ажиллах санамж бичгийг 2018.06.29-ний өдөр байгуулав.

5.9 Барилга, хот байгуулалтын яам, Монголын Нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоотой хамтран 2018 оны 08 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд Завхан аймгийн Улиастай суманд баруун аймгуудын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхэлдэг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтнуудыг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах зорилгоор “Сургалт, зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан.



5.10 Мөн 2018 оны 09 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Сайншанд суманд Зүүн болон говийн аймгуудын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхэлдэг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтнуудыг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах "Уулзалт, зөвлөгөөн"-ийг зохион байгуулсан.



5.11 Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь нар 2018 оны 10-р сарын 11-ний өдөр Бүгд Найрамдах Чех Улсын Үйлдвэр, худалдааны дэд сайд Эдуард Муржицки, Улаанбаатар хот дахь Бүгд Найрамдах Чех Улсын Элчин сайдын яам болон БНЧУ-ын Худалдаа аж үйлдвэрийн танхимын төлөөлөгчидтэй ажил хэргийн уулзалт зохион байгууллаа.



5.12 2015 оны 9 дүгээр сард Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)-ын Дээд хэмжээний чуулганаас "Тогтвортой хөгжлийн зорилт-2030" хөтөлбөрийг 17 зорилго, 169 зорилттойгоор батлан гаргасны дагуу Монгол Улс тус хөтөлбөрийн биелэлтийг хэрхэн хангаж байгааг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх зорилгоор Зохицуулах зөвлөлөөс "Тогтвортой хөгжлийн зорилт-2030" хөтөлбөрийн 6 дугаар зорилгын шалгуур үзүүлэлт тооцох төслийн саналыг 2018.10.24-ний өдөр ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс-т хүргүүлэв.

5.13 Дархан-Уул аймгийн Дархан хотод 2018.04.19-20-ны өдрүүдэд ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын удирдах албан хаагчдын мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох зорилгоор "УХАТ-2018" сургалтыг зохион байгуулав.





5.14 Орон нутгийн Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд “Цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, төлбөр тооцох аргачлал”, “Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийн хэмжээ”-ний талаар заавар, зөвлөгөө өгөх сургалтыг 2018 оны 09 дүгээр сарын 06, 07, 13,14-ний өдрүүд зохион байгуулав.

5.15 Зохицуулах зөвлөлөөс Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбар үүсч хөгжсөний 87 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын 180 гаруй төлөөллийг оролцуулсан уулзалт, зөвлөгөөнийг 2018.10.10-ны өдөр зохион байгуулсан.



5.16 Барилга, хот байгуулалтын яам, Монголын Нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоотой хамтран 2018.10.15-16-ны өдрүүдэд Төв аймгийн Зуунмод суманд Төвийн аймгуудын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхэлдэг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтнуудыг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах “Уулзалт, зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан.



5.17 УБТЗ-ын гаргасан хүсэлтийн дагуу тус байгууллагын харъяа Барилга ашиглалт үйлчилгээний 1, 2, 3-р ангийн инженер, техникийн болон санхүүгийн 20 гаруй ажилтнуудад зориулсан сургалтыг 2018.10.18-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулав.



5.18 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл нь Монгол Улсын Шинжлэх Ухааны Академитай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.





ЗУРГАА. ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

мян.төг

ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ХУВЬ
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	774,612.00	676,805.90	-
ҮНДСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГООС САНХҮҮЖИХ	774,612.00	670,930.70	87%
ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГООС САНХҮҮЖИХ	-	5,875.20	-
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	774,612.00	723,787.70	93%
ЦАЛИН ХӨЛС БОЛОН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ	431,325.40	389,887.90	90%
БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ	53,250.00	52,642.00	99%
ХАНГАМЖ, БАРАА МАТЕРИАЛЫН ЗАРДАЛ	24,517.00	23,820.70	97%
ЭД ХОГШИЛ, ИХ ЗАСВАР	98,635.10	9,718.10	101%
ТОМИЛОЛТ, ЗОЧНЫ ЗАРДАЛ	47,664.00	44,798.30	94%
БУСДААР ГҮЙЦЭТГҮҮЛСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР	5,688.00	2,525.30	44%
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДАЛ	94,672.50	94,427.80	100%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,860.00	15,967.60	85%
АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	20.00	-

ДОЛОО. ДҮГНЭЛТ



Тус Зохицуулах зөвлөл нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиар олгогдсон чиг үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд 2018 онд нийт 48 ажил хийхээр төлөвлөснөөс 47 арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр гүйцэтгэж /гүйцэтгэл 98 хувь/, 1 ажил дуусаагүй 40 хувийн гүйцэтгэлтэй байна.

Ариутгах татуургын системд учруулсан хохирлын төлбөр тооцох журам боловсруулах, холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах, нийслэл, орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын шугам, сүлжээний өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх ажлууд нь тус Зохицуулах зөвлөлөөс хамаарахгүй шалтгааны улмаас бүрэн хийгдээгүй болно.

Зохицуулах зөвлөлөөс хэрэгжүүлсэн тариф болон бусад үйл ажиллагааны зохицуулалтын үр дүнд Улаанбаатар хотын хэмжээнд ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн орлого 10 хувиар өсч, алдагдал 6 орчим тэрбум төгрөгөөр буурах, хөдөө орон нутгийн хэмжээнд орлого 20 хүртэл хувиар өсч, үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэх боломж нөхцөл бүрдсэн байна.

Ийнхүү ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны зохицуулалтаас салбарын үйлчилгээ, санхүү, эдийн засгийн байдалд ахиц дэвшил гарч байгаа нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд зохих хувь нэмэр оруулж байна.

--- о О о ---





ХҮН

БАЙГАЛЬ



УС



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

🏠 "Монгол Ньюс" тауэрын 6 давхар, 8-р хороо, Их тойруу 81/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

☎ (+976) 7014-7447
🌐 <http://www.wsrc.gov.mn/>
✉ info@wsrc.mn